



МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА

Сэдэв:

- Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт түвшнийг шинжлэх нь
- Инфляцийн бүтцэд гарч буй өөрчлөлт, түүний тогтвортой эсэхийг шинжлэх
- Үйлдвэрлэлийн зөрүүг тооцох олон хувьсагчийн аргачлал, бусад аргуудтай харьцуулах нь
- Валютын ханшийн эдийн засагт үзүүлэх нөлөө
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт
- Гадаад секторын эрсдэл, тогтворгүй байдал
- Арилжааны банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс
- Арилжааны банкны өөрийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах нь
- Эрсдлийн удирдлагын талаар-чөлөөт сэдэв

Нэг. Зорилго:

- Эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутнуудын Монгол улсын эдийн засаг, түүн дотроо мөнгөний бодлогын онол болон практик мэдлэгийг сайжруулах, оюутнуудын эрдэм шинжилгээний ажил хийх чадварыг хөхүүлэн дэмжихэд оршино.

Хоёр. Судалгааны ажилд тавигдах ерөнхий шаардлага:

- Судалгааны ажил нь практик ач холбогдолтой, шинжлэх ухааны үндэслэлтэй болон цаг үеийн асуудлыг хөндсөн байна. Хуралд оюутнууд багаар оролцож болох бөгөөд нэг баг дээд тал нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Гурав. Материал хүлээн авах хугацаа, илтгэлийн хэмжээ:

- Илтгэлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 12.00 цаг хүртэл Монголбанкны бичиг хэрэгт хүлээн авна;
- Судалгааны ажлаа бичгийн А4 цаасан дээр бичих бөгөөд дээд тал нь 15 хуудсанд багтсан байх ёстой. Мөн мэргэжлийн багш, судлаачаар удирдуулсан байх;
- Илтгэл нь гарчиг, агуулга, оршил, дүгнэлт ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх бөгөөд хэлэлцүүлэх хугацаа 10 минут, асуулт хариулт 5 минут үргэлжилнэ.

Дөрөв. Эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалт:

- **1-р шат** Зохион байгуулах комисс илтгэлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг уншиж, 6 илтгэлийг эцсийн шатны шалгаруулалтад оруулна.
- **2-р шат** Монголбанкны мэргэжилтнүүдээс бүрдсэн шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр Эрдэм шинжилгээний бага хурал 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагт Монголбанкны Б байрны 5 давхрын хурлын зааланд болно.

Тав. Шагнал, урамшуулал:

- 1-р байр - Өргөмжлөл, 600 000 /зургаан зуун мянган төгрөг/
- 2-р байр - Өргөмжлөл, 400 000 /дөрвөн зуун мянган төгрөг/
- 3-р байр - Өргөмжлөл, 300 000 /гурван зуун мянган төгрөг/

Дэлгэрэнгүй мэдээллийг 310081 утсаар лавлана уу. /Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв/